



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

ДОТООДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ, СТАТИСТИК

2022 оны 01 дугаар сар 20

ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН ЯАМ
НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

Хаяг: Хан-Уул дүүрэг 21-р хороо, ИНУТ-ийн байр 105 тоот
Улаанбаатар хот 17120, Монгол Улс
Утас/Факс: (+976)-71-285011, 71-285040/ (+976)-71-70049974
Веб хаяг: www.aaib.gov.mn, имэйл: aaib@aaib.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын Иргэний Нисэхийн салбар жил ирэх бүр эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд уул уурхайн үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбартай уялдан ачаа, зорчигч эргэлтийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг дагаад агаарын тээвэрлэгч компаниуд агаарын хөлгийн паркын хүчин чадлаа нэмэгдүүлж, орон нутагт төдийгүй олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулсаар байна.

“Изинис Эйрвэйз” ХХК 2019 оны 02 дугаар сарын 20-нд үйл ажиллагаагаа дахин сэргээж B737-700 EI-ULN, B737-7K2 EI-GVW бүртгэлийн дугаартай 2 агаарын хөлгөөр нислэг үйлдэж байна.

Монгол улсад - B767-300 агаарын хөлөг-1, B737-800 агаарын хөлөг-3, B737-8 MAX-1, B737-700 агаарын хөлөг-2, B737-300 агаарын хөлөг-1, ATR72-212A агаарын хөлөг-2, Embraer EMB-145LR агаарын хөлөг -2, Embraer ERJ190-100LR агаарын хөлөг -1, A319-112 агаарын хөлөг-1, Fokker F27 Mk050 агаарын хөлөг-1, (Бусад - Ми-8АМТ-1, CESSNA 208В-4, Airbus EC130 Т2-2, AS 350В3-2, Airtractor АТ602 -1, Ан -2 агаарын хөлөг -1) зэрэг агаарын хөлгүүд ашиглагдаж байна.

Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй 10 агаарын тээвэрлэгчээс төрийн өмчийн “МИАТ” ХК - 5(2-нь Ирланд улсад бүртгэлтэй), хувийн хэвшлийн “Аэромонголиа” ХХК -3, “Хүннү Эйр” ХХК -4, “Изинис Эйрвэйз” ХХК-2(Ирланд улсад бүртгэлтэй), “Геосан” ХХК-1, “Скай Жет” ХХК-2, “Томас Эйр” ХХК-1, “Тэнгэрийн улаач Шинэ” ХХК-1 “Монголиан Эйрвэйз” ХХК-2, “Монголын Нисэхийн Академи” ХХК-3 нийт 24 агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Дараах агаарын тээвэрлэгчээс “Монголиан Эйрвэйс Карго” ХХК-2, “А-Жет Авэйшн” ХХК-2, “Монголиан Эйрвэйс” ХХК-2, “Геосан” ХХК-3, “Топ Экстрим Экшин Монголиа” ХХК-4, “Сэлиэр Авиэшн Монголиа” ХХК-1, “Континентал Эйр”

ХХК-1, “Залуу бүргэд Женерал Авэйшн” ХХК-1, Монголын Алт “МАК” ХХК-1, “Скай такси” ХХК-1, “Аэрохели” ХХК-1, “Дисковиери Авиэшн” ХХК-1, “Сатурн Экстрем Монголиа” ХХК -1 Агаарын бөмбөлөгтэй байна.

Хувь хүний нэр дээр 2 нийт 22 агаарын хөлөг Монгол улсад бүртгэлтэй нислэг үйлдээгүй байна. /НААХЗА-с авсан мэдээллээр/

Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны судалгаагаар агаарын тээвэрлэгч байгууллагууд тэдгээрийн агаарын хөлөгтэй холбоотой осол, ноцтой зөрчил болон зөрчил 2016-2021 оны 12-р сарын 30-ны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 283 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд:

- Осол – 1
- Ноцтой зөрчил – 7
- Зөрчил, дутагдал –275


Тус албанаас дээрх онуудад агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан 15 тайлан, нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой 77 зөвлөмж гаргасан байна.

Осол, зөрчлийн статистикийг ангилж 1 дүгээр графикт “Осол болон Ноцтой зөрчлүүд”, 2-4 дүгээр графикт “Аюулгүй ажиллагаатай холбоотой” зөрчлүүд, 5-6 дугаар графикт “Авиа компани болон агаарын хөлөгтэй” холбоотой зөрчлүүд, 7-9 дүгээр графикт шувуутай холбоотой зөрчлүүд, 10-13 дугаар графикт зөвлөмжтэй холбоотой статистикуг орууллаа.

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ОСОЛ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА

Д/Д	Он	Осол	Ноцтой зөрчил	Зөрчил	Нийт тохиолдол	Шинжлэн шалгасан тайлан	Аюулгүй ажиллагааны зөвлөмж	Шувуутай холбоотой зөрчил
1	2016	0	4	35	39	2	29	10
2	2017	1	1	66	68	3	12	11
3	2018	0	0	61	61	2	3	11
4	2019	0	0	59	59	2	5	14
5	2020	0	2	29	31	2	11	8
6	2021	0	0	25	25	6	14	8
7	Нийт	1	7	275	283	17	74	62

График 1: Осол болон ноцтой зөрчлийн тоо /2016-2021/



Зөрчлийн талаар.

Агаарын хөлгийн нислэгийн үед тохиолдсон зөрчлүүдийг мэдээллийн дагуу бүртгэгдсэн байдлаар ангилж үзэхэд:


№	Ангилал \ Оноор	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт
1	Агаарын хөлгийн хөдөлгүүр унтарсан	3	-	1	-	1	-	5
2	Хөдөлгүүр туслах хөдөлгүүртэй холбоотой						1	1
3	Агаарын хөлгийн техник, эд ангийн ажиллагаатай холбогдолтой	14	15	26	20	9	1	85
4	Тасалдсан хөөрөлт үйлдсэн						1	1
5	Хүний хүчин зүйл	-	-	1	2	-	3	6
6	Битүүмжлэл алдагдах	1	-	-	-		1	2
7	Дугуй	1	1	-	-	1	2	5
8	Ойртолт	1	1	2	-	-	-	4
9	Шувуутай холбогдолтой	10	11	11	14	8	8	62
10	2-р тойрог нислэгт гарсан	1	23	13	18	6	2	63
11	Цаг агаартай холбогдолтой	1	9	2	-	-	-	12
12	Нислэгийн холбоо барих	1	2	1	3	2	-	9
13	Нислэгийн зөвшөөрөл	-	1	-	1	-	-	2
14	Хилийн бүсэд нислэг үйлдсэн						1	1
15	НХУдирдлагын тоног төхөөрөмжтэй холбогдолтой					2	2	4
16	Цонхны шил цуурах	1		2	-	-	1	4
17	Гадны биетээс			2	1	-	-	3
18	Амьтантай холбогдолтой	1	-	-	-	-	-	1
19	Бусад	-	3	-	-	-	2	5
20	Нийт	35	66	61	59	29	25	275



❖ График 2: Зөрчлийг шалтгаанаар ангилвал /2016-2021/

Мөн өнгөрсөн 5 жилд гарсан нийт 275 зөрчлийг шалтгаанаар нь тодорхойлвол Техникийн дутагдалтай холбоотой 85 зөрчил бүртгэгдсэн нь нийт зөрчлийн 30,9%, Шувуутай холбоотой зөрчил 62 буюу 22,5%, 2-р тойрогт гарсан зөрчил 63 буюу 22,9%, Цаг агаартай холбоотой зөрчил 12 буюу 4,36%-ийг эзэлж байна.


2016-2021 онд




❖ График 3: Зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал /2016-2021/

2016-2021 онд бүртгэгдсэн зөрчлийг зөвхөн нислэгийн үе шатаар ангилвал нийт 275 зөрчил бүртгэгдэснээс Газарт/зогсоолд-46 буюу нийт зөрчлийн 16,7%-ийг, Явгалалт-25 буюу 9,09%-ийг, Хөөрөлт- 43 буюу 15,6%-ийг, Нислэгт-29 буюу 10,5%-ийг, Буултын үед-127 зөрчил гарсан нь нийт зөрчлийн 46,1% -ийг эзэлж байна.

2016-2021 он




❖ График 4: Зөрчлийг сараар ангилвал /2016-2021/




Дээрхи графикт 2016 - 2021 онуудад гарсан аюулгүй ажиллагаатай холбоотой зөрчлүүдийг нэгтгэн сар түс бүрээр ангилсан бөгөөд сүүлийн 5 жилийн дунджийг харвал 1, 6 болон 8 дугаар сард бүртгэгдсэн зөрчлийн тоо бусад сараасаа илүү байгаа нь тухайн сард түлхүү анхаарч аюулгүй ажиллагааг хангуулах, урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах шаардлагатай харагдаж байна.

❖ График 5: Авиа компаниудын осол зөрчлийн тоо /2016-2021/

Манай улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгч байгууллагуудын зөрчлийн бүртгэлийг сүүлийн 5 жилээр харвал нийт 275 зөрчил дутагдал бүртгэгдсэн байгаагаас МИАТ компанитай холбоотой 117 зөрчил дутагдал буюу /42.5%/, Аэромонголиа 50 буюу /18,18%/, Хүннү Эйр 36 буюу /13,09%/, Бусад 74 буюу /26.9%-ийг эзэлж байна.



❖ График 6: Агаарын хөлгийн маягаар ангилсан осол, зөрчлийн тоо /2016-2021/



Өнгөрсөн 2016-2021 онд агаарын хөлөгтэй холбоотой нийт 275 зөрчил бүртгэгдсэн байгаагаас Boeing агаарын хөлөгтэй холбоотой зөрчил -144 байгаа нь нийт зөрчлийн 52.3% ,Fokker - 50 агаарын хөлөгтэй холбоотой зөрчил -30 /10.9%,(F50 агаарын хөлгийг 2019 оноос ашиглахаа болисон, Монголын Нисэхийн академи ХХК 2021 оны 9-р сард нэг онгоцтой болсон байна.), ATR72 агаарын хөлөгтэй холбоотой зөрчил - 17 /6.18%, EMB-145LR агаарын хөлөгтэй холбоотой зөрчил-37 /13.45%, бусад буюу /PC6, A330, A319, EC145, H125/ зэрэг агаарын хөлөгтэй холбоотой зөрчлүүд - 36 байгаа нь нийт зөрчлийн 13.09 хувийг эзэлж байна.

ШУВУУТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК

Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны судалгаагаар агаарын тээвэрлэгч байгууллагууд тэдгээрийн агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн тохиолдол 2016-2021 онд нийт 62 (Улаанбаатар хотод -22, Орон нутагт-9, Хан Бумбат НБ-д -15, Олон улсад -9, тодорхойгүй -6) бүртгэгдсэн байна.


График №7: Шувуутай холбоотой зөрчлийг байршил болон оноор



Өнгөрсөн 5 жилийн хугацаанд шувуутай холбоотой 62 зөрчил бүртгэгдэж нийт зөрчлийн 22.5%-ийг эзэлж байгаа нь нислэгийн давтамж болон агаарын тээвэрлэгч байгууллагууд тэдгээрийн агаарын хөлгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.


❖ График №8: Шувуутай холбоотой зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал /2016-2021/

Нийт 62 шувуутай холбоотой зөрчлийг нислэгийн үе шатаар ангилвал “Буултын” үед 34 зөрчил буюу нийт зөрчлийн 54.8% хувийг, “Хөөрөлтийн” үед 17 буюу 27.4% -ийг тус тус эзэлж байна.



✦ График №9: Шувуутай холбоотой зөрчлүүдийг сараар ангилвал /2016-2021/

Доорхи графикт шувуутай мөргөлдсөн тохиолдлыг сар түс бүрээр ангилсан бөгөөд жилийн дунджийг харвал 7, 8, 9 болон 10 дугаар сард бүртгэгдсэн зөрчлийн тоо бусад саруудаас илүү байна.



Буянт-Ухаа ОУНБ-ын орчимд нийт 76 зүйл шувуу бүртгэгдээд байгаагийн 30.2% нь суурин, 60.9% нь нүүдлийн, 4% нь өвөл ирдэг, 5.6% нь цэвэрлэх байгууламжийн усанд өвөлждөг шувууд байна.

ЗӨВЛӨМЖТЭЙ ХОЛБООТОЙ СТАТИСТИК



Тус албанаас 2012-2021 оны хооронд аюулгүй ажиллагаатай холбоотой нийт 175 зөвлөмж гаргасан байна. Доорх графикт Агаарын тээвэрлэгч байгууллагууд, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нислэгийн цаг уурын төвд болон Шувуутай холбоотой гаргасан зөвлөмжүүдийг он тус бүрээр нь оруулсан болно.

График 10: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн статистик /2012-2021/

Зөвлөмж өгсөн байгууллагууд





График 11: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн статистик /2012-2021/


Агаарын тээвэрлэгч байгууллагууд






❖ График 12: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн ангилал /2012-2021/

Өнгөрсөн 2012-2021 онуудад осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийг холбогдох хэсгээр нь ангилвал нийт 175 зөвлөмжийн 22-нь Иргэний нисэхийн дүрэмтэй холбоотой зөвлөмж, 56-нь Сургалттай холбоотой зөвлөмж, 63-нь заавар, журамтай холбоотой аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргасан байна.




❖ График 13: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилт /2015-2021/

Мөн дээрх онуудад гарсан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн бие лэлтийг сүүлийн 7 жил буюу 2021.12.30-ны байдлаар харвал нийт 91 зөвлөмж гарснаас Хэрэгжсэн буюу 100%-тай - 82, Хэрэгжих шатандаа буюу 80%-тай - 1, Хэрэгжих шатандаа буюу 50%-тай – 3, Хэрэгжих шатандаа буюу 20%-тай – 4, Хэрэгжээгүй буюу 0%-тай - 1 зөвлөмж байгаа нь нийт зөвлөмжийн хэрэгжилт 93.5%-тай байна.



❖ График 16: Хамтран ажилласан гадаадын байгууллагууд /2015-2021/

Дээрх онуудад гаргасан тайлан, зөвлөмжийг дараах улсуудын шинжлэн шалгах байгууллагуудтай (ОХУ-IAC, АНУ-NTSB, Франц-BEA, Ирланд-AAIU, Канад-TSB, Англи- AAIB, Хятад-CAAC, Солонгос-ARIAV, Сингапур-AAIB), мөн АНУ-ын Воеинг компани, ХБНГУ-ын Люфтханз компани, ИКАО - Олон улсын шинжээчдийн нийгэмлэг (ISASI) зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж гаргасан болно.



❖ График 17: MOU байгуулсан гадаадын шинжлэн шалгах байгууллагууд /2007-2021/

Гадаад улсаас монгол улсад нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн харьяалах орны шинжлэн шалгах байгууллагуудтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлыг 2007 оноос эхлүүлж ОХУ, БНСУ, БНФУ-тай байгуулсан байна. 2013 оноос БНХАУ, Канад, Сингапур, БНАСАУ, Япон, Казакстан улсуудын шинжлэн шалгах байгууллагатай MOU байгуулан ажиллаж байна.



❖ График 18: MOU байгуулсан дотоодын байгууллагууд /2005-2021/

Тус алба нь 2005 оноос эхлэн ИНЕГ-ын НААХЗА, ИНЕГ, Тээврийн прокурор, Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэн, ШУТИС-ийн МИСургууль, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр болон Дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна.



№	Нислэгийн төрөл	I-XII сарын нислэгийн гүйцэтгэл					2017 оныг 2021 оной харьцуулахад өссөн	
		2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	тоо	хувь
1	Олон улсын өнгөрөлт	110953	123296	133663	71442	68715	-42238	-38.06
	Өмнөх оноос өссөн хувь	9.6	10.01	7.8	-46.6	-4.0		
2	Олон улсын хөөрөлт,буулт	7921	8505	10142	1721	2435	-5486	-30.74
	Өмнөх оноос өссөн хувь	15.08	6.8	19.2	-83.0	29.3		
3	Орон нутгийн хөөрөлт,буулт	5675	6394	7967	5563	4663	1012	-17.83
	Өмнөх оноос өссөн хувь	12.6	11.2	24.6	-30.2	-16.17		
	Нийт нислэгийн дүн:	124549	138195	151772	78726	75813	-48736	-39.1
	Нийт нислэгийн өмнөх оноос өссөн хувь	10.2	10.5	9.8	9.8	-3.7		Энэ нь Ковид19-той холбоотой.
	Сэтгэлийн дундаж хувь	7.32						

Сүүлийн 5 жилийн нийт нислэг



Сүүлийн жилүүдэд 47 улсын 181 авиакомпаний агаарын хөлгүүд манай улсын нутаг дэвсгэр дээгүүр Олон улсын өнгөрөлтийн болон буулт, хөөрөлтийн тогтмол хуваарийн, цагийн хуваарийн бус нислэг үйлдэж байна.

НТОЗШША-ны гаргасан тайлан, зөвлөмжид хяналт тавих, хэрэгжүүлэх талаар ИКАО-ын Annex 13, Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, ИНД-203 –д заасан талаар

Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын бүлэг 7:

7.4 The Preliminary Report shall be sent by facsimile, e-mail, or airmail within *thirty days* of the date of the accident unless the Accident/Incident Data Report has been sent by that time. When matters directly affecting safety are involved, it shall be sent as soon as the information is available and by the most suitable and quickest means available.

6.3 If the State conducting the investigation receives comments within *sixty days* of the date of the transmittal letter, it shall either amend the draft Final Report to include the substance of the comments received or, if desired by the State that provided comments, append the comments to the Final Report. If the State conducting the investigation receives no comments within sixty days of the date of the first transmittal letter, it shall issue the Final Report in accordance with 6.4, unless an extension of that period has been agreed by the States concerned.

6.5 In the interest of accident prevention, the State conducting the investigation of an accident or incident shall make the Final Report publicly available as soon as possible and, if possible, within *twelve months*.

6.6 If the report cannot be made publicly available within *twelve months*, the State conducting the investigation shall make an interim statement publicly available on each anniversary of the occurrence, detailing the progress of the investigation and any safety issues raised.

ИНД-203

12.2 Алба нь Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг гарсан өдрөөс хойш **30 өдөрт** багтаан урьдчилсан тайланг гаргах ба аюулгүй ажиллагаанд шууд нөлөөлж болзошгүй байвал урьдчилсан тайланг аль болох яаралтай гаргаж дараах улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ

12.5 Алба нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан эцсийн тайлангийн төслийг бүртгэсэн улс, тээвэрлэгчийн харьяалах улс, зохион бүтээсэн улс, үйлдвэрлэсэн улсад, мөн шинжлэн шалгах ажиллагаанд оролцсон улс орнуудад илгээх бөгөөд албан бичгийг илгээсэн өдрөөс хойш **60 өдөрт** багтаан санал хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.

12.7 Алба нь тайлангийн төсөл илгээсэн улсуудаас саналыг хүлээн авч, хүлээн авсан саналын агуулгыг тусгахын тулд эцсийн тайлангийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

12.10 Алба нь аль болох богино хугацаанд эцсийн тайланг гаргах ба хэрэв боломжтой бол осол гарсан өдрөөс хойш **12 сард** багтаан гаргана. Хэрэв тайланг **12 сард** багтаан гаргах боломжгүй бол шинжлэн шалгах ажлын явц, гаргаж тавьсан аливаа аюулгүй байдлын асуудлыг нарийвчлан харуулсан дотоодын тайланг гаргана.

НТОЗШША-ны гаргасан тайлан, зөвлөмжид хяналт тавих, хэрэгжүүлэх талаар ИКАО-ын Annex 13, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, ИНД-203 –д заасан талаар

Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын бүлэг 6:

RESPONSIBILITY OF A STATE RECEIVING OR ISSUING SAFETY RECOMMENDATIONS

Action on safety recommendations


6.10 A State that receives safety recommendations shall inform the proposing State, within **ninety** days of the date of the transmittal correspondence, of the preventive action taken or under consideration, or the reasons why no action will be taken.

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 8-р зүйлийн 8.4.7-д

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан дүгнэлтийг үндэслэн цаашид осол, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах бүрэн эрх нь **ИНЕГ**-т байдаг.

ИНД -203: 13.1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь тухайн осол, зөрчлийг шинжлэн шалгасан шалгалтын үр дүнд тулгуурлан энэ төрлийн осол, зөрчил дахин давтан гарахаас урьдчилан сэргийлэх Аюулгүй ажиллагааны зөвлөмжийг гаргаж ИНЕГ болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

- 13.2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийг авсан аливаа байгууллага этгээд зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ба ИНЕГ зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч, эргэж мэдэгдэх, хяналт тавих үүрэгтэй.



Анхаарал тавьсанд баярлалаа.